



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 9/56

Хөхбүрд

Нийгмийн баталгаа хангах хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчийг ажиллах орчин нөхцлөөр хангах, сайжруулах албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөх зорилгоор нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Төрийн албан хаагчийн нийтлэг эрх үүргийг хэрэгжүүлэх, мөрдлөг болгох, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг ёс зүйн зөвлөлийн дарга болон гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Ганцоож)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Ж.ХАТАНБААТАР

642301081

Сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23 -ний өдрийн 156 дугаар Захирамжийн нэгдүгээр хавсралт

**БАЯН-ОВОО СУМЫН ЗДТГ-ЫН ТӨРИЙН АЛБАН
ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР**

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Байгууллагын хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөр нь Төрийн албаны тухай хууль, Байгууллагын дотоод журам, Хамтын гэрээнд заасан Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах тухайн байгууллагад дутагдаж буй боловсон хүчин, мэргэшсэн багийг бүрдүүлэх, албан хаагчийг сургаж хөгжүүлэх, чадавхижуулах, нийгмийн баталгааг хангаж, тогтвор сууршилтай ажиллуулах аливаа асуудлыг бодлого төлөвлөгөө, зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангаснаар аймаг, нийслэл хэмжээнд өрсөлдөх чадвартай мэдлэг боловсролтой тогтвор суурьшилтай мэргэжилтэн бий болгох нь энэ хөтөлбөрийн зорилго мөн.

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1 Боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх сургалтанд хамруулах, ажлын байран дээр суралцах боломж нөхцлийг бүрдүүлэх, шаардлагатай урт болон богино хугацааны сургалт семинарт бүрэн хамруулах

3.2 Төрийн албаны тухай хуульд заасан амралт, шагнал урамшуулал, тусламж олгох

3.3 Чөлөөт цагаараа мэргэжил сонирхолын дагуу ном бүтээл туурвих, орчуулга хийх, оюуны чадвараа ашиглан орлого олох боломжийг дэмжих

3.4 Албан тушаалын тодорхойлолтонд зааснаас өөр ажил үүргийг цалин хөлсгүй давхар гүйцэтгүүлэхгүй байх

3.5 Бусад мэргэжилтэнтэй туршлага мэдлэг чадвараа солилцох боломжоор хангах

3.6 Сар бүр ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр албан хаагчдад орон нутгийн төсвөөс нэмэгдэл урамшуулал олгох,

3.7 Ажил үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тохиолдолд унаагаар хангах,

3.8 Сар бүрийн хоолны мөнгө 8000 төгрөгийг нэмэгдлээр олгох,

3.9 Ажлын байрыг цэвэр байлгах, засвар үйлчилгээг хийх,

3.10 Шаардлагатай техник хэрэгсэл, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах,

3.11 Эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд жил бүр хамруулах

3.13 Жилд 1-ээс доошгүй удаа витаминжуулалтад хамруулж дарлаажуулах,

3.14 Албан хаагчдад түлшний үнийн хөнгөлөлт олгох

3.15 Албан хаагчдын хүүхдэд эх үрсийн баяраар 50% хөнгөлөлттэй хүүхдийн бэлэг өгөх

3.16 Төрийн албаны тухай хууль, Дотоод журам, Хамтын гэрээ, Хөдөлмөрийн гэрээнд заасан бусад нийгмийн баталгаагаар хангах

3.17 Төрийн албан хаагчдыг мэргэжил, мэргэшил дээшлүүлэхэд нь сургалтын төлбөрийн хөнгөлөлт болон сургалтын төлбөрийг тэтгэлгээр дэмжих

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

4.1 Хөтөлбөрт заасан арга хэмжээг Сумын ЗДТГ-аас зохион байгуулан ажиллах.

4.2 Хөтөлбөрт заасан арга хэмжээний үйл явц үр дүнд ЗДТГ-ын дарга хяналт тавина.

4.3 Хөтөлбөрийн санхүүжилт эх үүсвэр нь:

-Жил бүрийн төсөвт тусган оруулах

-Дундын сангийн хуримтлал

-Үйлдвэрчний эвлэлийн татвар

-Бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Тав. Хөтөлбөрийн хугацаа

5.1 Хөтөлбөрийг 2023-2026 онд хэрэгжүүлнэ.

5.2 Шаадлагатай тохиолдолд Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Зургаа.Хөтөлбөрийн үр дүн

6.1 Боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх сургалтанд хамруулах, ажлын байр дээр суралцах нөхцлийг бүрдүүлсэн байх (сургалтанд хамрагдсан тоогоор)

6.2 Албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирч, ажлын бүтээмж нэмэгдэх, ажлын үр дүн дээшилсэн байна.

6.3 Албан хаагчид эрүүл мэндийн эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамрагдсан байх

6.4 Ажиллах орчин нөхцөл тав тухтай болж, албан хаагчид тогтвор сууршилтай ажиллах боломжоор хангагдсан байх